



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/145

Улаанбаатар хот


┌ Маргаан шийдвэрлэх комиссын тогтоолыг ┐ баталгаажуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Оюуны өмчийн газрын дэргэдэх Маргаан шийдвэрлэх комиссын ажиллах журмын 5.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн В.Болормаа, И.Цэрэндулам нараас ирүүлсэн мэдүүлгийн 10-2017-0006106 дугаартай “26/1 номерын торомны ноосон утсаар нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх арга” нэртэй бүтээлд шинэ бүтээлийн патент олгохоос татгалзсан шийдвэрийг хүчингүй болгуулах тухай гомдлын шаардлагыг хангаж шийдвэрлэсэн Оюуны өмчийн газрын дэргэдэх Маргаан шийдвэрлэх комиссын 2020 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 11 дүгээр тогтоолыг баталгаажуулсугай.

2. Маргаан шийдвэрлэх комиссын тогтоолыг баталгаажуулсантай холбогдуулж хэрэгжилтийг хангаж ажиллахыг Маргаан шийдвэрлэх комисс /С.Ганзориг/-т даалгасугай.

ДАРГА



Ц.АЗБАЯР